


Хашаа

Поликарпусийн гэрийн урд хашаа байдаг. Хашаа n ширхэг ижил өргөнтэй нэг нь нөгөөгийгөө араас зүүнээс баруун тийш цувж байрласан банзнуудаас бүрддэг. i дэх банзны өндөр h_i метр, өөр банзнууд өөр өндөртэй байж болдог байна.



Зураг: $n = 7$ ба $h = [1, 2, 6, 1, 1, 7, 1]$ тохиолдол

Поликарпус дээд зэрэглэлийн төгөлдөр хуур худалдаж авсан ба үүнийгээ гэртээ хэрхэн оруулах талаар бодож байна. Төлөвлөгөөгөө гүйцэлдүүлэхийн тулд тэрээр хашаанаасаа k ширхэг дараалласан банзнуудыг авах хэрэгтэй болно. Өндөр банзнуудыг хашаанаас салгаж авахад илүү хэцүү болохоор Поликарпус өндрүүдийн нийлбэр нь байж болох хамгийн бага утга бүхий дараалласан k ширхэг банзнуудыг олохыг хүсч байлаа.

Нийт өндрийн хэмжээ нь хамгийн бага байдаг k ширхэг дараалласан хашаануудын индексүүдийг олдог програм бичээрэй. Хашаа Поликарпусийн гэрийг тойроод биш гэрийнх нь урд байдгийг анхааруулъя (өөрөөр хэлбэл хашаа тойрог биш).

Input

Оролтын эхний мөрөнд n болон k ($1 \leq n \leq 1.5 \cdot 10^5$, $1 \leq k \leq n$) гэсэн хашааны банзнуудын тоо болон төгөлдөр хууранд зориулж гаргах нүхний өргөнг илэрхийлэх 2 ширхэг бүхэл тоо байна. 2 дахь мөрөнд хашааны i дэх банзны өндөр h_i байхаар h_1, h_2, \dots, h_n ($1 \leq h_i \leq 100$) бүхэл тоонуудын дарааллууд байна.

Output

$j, j + 1, \dots, j + k - 1$ банзнуудын өндрийн нийлбэр нь боломжит хамгийн бага утгатай байх j -г хэвлэ. Ийм хэд хэдэн j байвал тэдний багыг нь хэвлээрэй.

Example

Input:

```
7 3
1 2 6 1 1 7 1
```

Output:

```
3
```